



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 21 өдөр

Дугаар A/463

Булган сум

### Гүйцэтгэгчтэй гэрээ шууд байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.4, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь заалт, Засгийн газрын 2024 оны “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өргтийн дээд хязгаар тогтоох тухай” 02 дугаар тогтоол, Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 108 дугаар тушаалаар батлагдсан “Зураг төслийн жишиг үнийн дүрэм” БД 81-16-20, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 сарын 05-ны өдрийн XIX/08 дугаар “Булган аймгийн 2024 оны төсөв батлах тухай” тогтоолын 3 дугаар хавсралтын 2.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Булган сумын Соёл амралтын цэцэрлэгт хүрээлэнгийн тоглоомын барилгын засварын ажлыг 19 500 000 (арван есөн сая таван зуун мянга) төгрөгөөр “Вилла проект” ХХК-тай гэрээ шууд байгуулах эрхийг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга (Ү.Бямбасүрэн)-д олгосугай.

2.Гэрээнд заагдсан ажлуудыг холбогдох хууль, журам, норм дүрмийн дагуу тогтоосон хугацаанд чанартай гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг “Вилла проект” ХХК-ийн захирал (Ч.Сод-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

3.Дээрх зураг төсөл боловсруулах ажилд чанарын болон хугацааны хяналт тавьж хүлээн авахыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга (Ү.Бямбасүрэн)-д даалгасугай.

4.Дээрх ажлуудын санхүүжилтийг аймгийн төсвийн хөрөнгө оруулалтын батлагдсан төсвөөс гэрээнд заагдсан үнийн дүнгээр санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Д.Батцогт)-д зөвшөөрсүгэй.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д үүрэг болгосугай.



6324010598